



“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 01

Улаанбаатар

Г

Т

Өрийг хувьцаагаар солих тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.8 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.3 дахь заалт, 87 дугаар зүйл, 88 дугаар зүйл, 38 дугаар зүйлийн 38.8 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалт болон Хот Девелопмент ХК-ийн 2021 оны 01 сарын 04-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

- Хот Девелопмент ХК болон Hot holdings S.A.R.L хооронд 2013 оны 06 сарын 11-ний өдрийн 01 дугаартай “Хөрвөх зээлийн гэрээ”, Зээлдүүлэгч Б.Лхагвадорж болон Hot holdings S.A.R.L хооронд 2019 оны 04 сарын 15-ны өдрийн “Зээл шилжүүлэх гэрээ”-ний дагуу 843,016,900 төгрөгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг Хот Девелопмент ХК-ийн 8,430,169 ширхэг энгийн хувьцаанд хөрвүүлэхийг зөвшөөрсүгэй.
- Өрийг хувьцаагаар солих төслийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
- Хот Девелопмент ХК-ийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.
- Хот Девелопмент ХК-ийн өрийг хувьцаагаар солихыг зөвшөөрсентэй холбогдуулан Хот Девелопмент ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг 843,016,900 төгрөгөөр нэмэгдүүлж, Хот Девелопмент ХК-иас дараах төрөл, үнэ, тоо ширхэг бүхий энгийн хувьцааг хаалттай хүрээнд нэмж гарган Зээлдүүлэгч Б.Лхагвадоржид эзэмшүүлсүгэй. Нэмж хувьцаа гаргаж буйтай холбогдуулан Хот Девелопмент ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

1) Хувьцааны төрөл	Энгийн
2) Тоо ширхэг	8,430,169 ширхэг
3) Нэгж хувьцааны үнэ	100 төгрөг
4) Хувьцааны нэрлэсэн үнэ	100 төгрөг
- Өрийг хувьцаагаар сольж буйтай холбоотойгоор Хот Девелопмент ХК-иас хаалттай хүрээнд нэмж гаргаж буй хувьцааг Хот Девелопмент ХК-ийн одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
- Хот Девелопмент ХК-ийн өрийг хувьцаагаар солих төсөл, журмыг хэрэгжүүлж ажиллах, өрийг хувьцаагаар солих болон их хэмжээний, сонирхлын зөрчилтэй хэлцэл

хийгдсэнтэй холбоотой хувьцаа эзэмшигчдийн шаардах эрх хэрэгжүүлэх журмыг батлах, хувьцаа эргүүлэн худалдан авах үнийг тогтоох, энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, түүнтэй холбоотой үүссэн асуудлыг тухай бүр шийдвэрлэж ажиллах бүрэн эрхийг Төлөөөлөн удирдах зөвлөлд олгосугай.

7. Хот Девелопмент ХК-ийн өрийг хувьцаагаар сольж буйтай холбоотойгоор Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох журмын дагуу мэдэгдэж, зөвшөөрөл авах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Н.Батгэрэл)-д даалгасугай.
8. Хот Девелопмент ХК-ийн өрийг хувьцаагаар сольж, хаалттай хүрээнд нэмж гаргаж буй хувьцааг бүртгэх шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо зөвшөөрөн, нэмэлт хувьцаа бүртгэгдсэний дараа компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газарт хандаж бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Н.Батгэрэл)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

/Д.ДАЯНБИЛГҮҮН/

